

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРААС 2019 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР
САРД ХИЙХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
2019.11.26-2019.12.10**

2019 оны 12 сарын 11-ний өдөр

Даланзадгад сум

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хариуцах нэгж, албан хаагч	Биелэлт	Үнэлгээ хувиар	
						Нэгж	ХШДАО НХ
1	2	3	4	5	6	7	8
1.	Виз зөвшөөрлийн чиглэлээр	Монгол Улсад байх хөрөнгийн баталгаагүй, визийн ангиллаас өөр зорилгоор ирж буй гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг тодорхой бүрдүүлэн, бүртгэл хөтлөж ажиллах.	Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцааж буй үндэслэл тодорхой байна.	Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар	Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 4 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан. Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 42 иргэнийг бүртгэж, 40 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.		
		Виз, урилга олголт, визийн шилжүүлэг, түр болон удаан хугацаагаар ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шуурхай хуулийн дагуу шийдвэрлэн, бүртгэл хөтлөж мэдээллийн санд баяжилт хийх.	Хуулийн дагуу хийгдсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Нийт 10 гадаадын иргэнд виз олгож, тэмдэгтийн хураамжийн 1.080.000 /нэг сая наян мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын дансанд тус тус тушаалган ажилласан болно.		
2.	Хяналт шалгалтын чиглэлээр	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Удирдамж батлуулж, холбогдох хууль тогтоомжийн хяналт шалгалтын ажлыг	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Тайлант хугацаанд 1 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг мэдээллийн дагуу зохион байгуулж, шалгалтад 1 аж ахуйн нэгж, байгууллагын 4 гадаадын иргэн		

1	2	3	4	5	6	7	8
					хамрагдсан байна. Энэ үеэр эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 2 иргэнийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан болно.		
3.	Албадан гаргах чиглэлээр	ГИЭЗБТХ зөрчсөн гадаадын иргэдийг Монгол Улсаас албадан гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх.	Холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар	Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 2 иргэнд 200.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт нийт 200000 төгрөгийг төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан.		
4.	Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр	1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах. 2.Албан хаагчдын цалин хөлс, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал засвар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж тусламж зэргийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.	Төсвийг үр дүнтэй зарцуулсан байх.	Нягтлан бодогч Нярав	Энэ оны 12 дугаар сард нийт 20 албан хаагчийн урьдчлгаа цалинд 5,100,000 төгрөгийг олгож, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,340,900 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 522,000 төгрөг, урсгал засварын зардалд 230,000 төгрөг, томилолтын зардалд 414,000 төгрөг, зочин төлөөлөгчийн зардалд 2,966,000 төгрөг, шуудан холбооны зардалд 25,415.50 төгрөг, тусламжид 1,015,225,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.		
		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог үнэн зөв гаргаж, холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнах.	Тайлан тооцоо хугацаандаа хүргэгдсэн байх.	Нягтлан бодогч Нярав	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 02-ны дотор гаргаж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан төв санхүүд хүргүүлэн ажилласан. 2019 оны 11 дүгээр сарын үнэт цаасны зарцуулалтын тайланг хяналтын улсын байцаагч, шатах тослох материалын зарцуулалтын тайланг жолооч нартай тооцоо нийлж хүлээн авч, тулгалт хийж нэгтгэн тооцоог үнэн зөв гаргаж энэ сарын 02-ны өдрийн дотор		

1	2	3	4	5	6	7	8
					Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлж ажилласан.		
		Авто машины ашиглалт, хяналт, техникийн бүрэн бүтэн байдал, жолоочийн хариуцлага, ур чадварт хяналт тавьж ажиллах.	Автомашины ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж аюулгүй байдал хангагдсан байна.	Нярав	Газрын албан хэрэгцээнд ашиглагдаж буй автомашинуудын хяналт бүртгэлийг тухай бүр хийн, шаардла гатай сэлбэг хэрэгслийг худалдан авч тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарч ажилласан. Тухайлбал, ланд 76 автомашины аккумуляторыг шинээр сольж ажилласан байна.		
		Газрын 2019 оны эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийж дүнг нэгтгэн гаргах.	Эд хөрөнгийн тооллогын комисс байгуулан, тооллогыг хийж гүйцэтгэн дүнг нэгтгэн холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Тооллогын комисс	Газрын даргын 2019 оны А/13 дугаар тушаалын дагуу бүсийн газрын 2019 оны эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулах комиссыг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан тооллогыг хийж гүйцэтгэн дүнг нэгтгэн ажиллаж байна.		
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр	Байгууллагын даргын батлан гаргасан тушаал, дээд газраас ирүүлсэн журам, шийдвэрийг тухай бүр албан хаагч нарт танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.	Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Байгууллагын даргын батлан гаргасан тушаал, шийдвэрийг тухай бүр албан хаагчдад танилцуулан ажилласан болно.		
		Албан хаагчдын сарын цагийн тооцоо гаргах, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг олгох.	Албан хаагчдын цалин хөлс хугацаандаа олгогдсон байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Албан хаагчдын 12 дугаар сарын урьдчилгаа цалинг 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдөр олгон ажилласан.		
		Баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах.	Хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тус газарт ирсэн албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар тус газарт ирүүлсэн 3 хариутай бичгийг хугацаанд нь хариуг хүргүүлж ажилласан байна.		

1	2	3	4	5	6	7	8
		Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх.	Өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байх.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Иргэн аж, ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тус газарт 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар албан хаагчаас болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.		
		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах.	Газрын ирсэн, явсан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл гомдлыг скайнердан цахим хэлбэрт оруулж, архив үүсгэсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тайлант хугацаанд тус газар явсан 13, ирсэн 4 албан бичгийг скайнердаж цахим хэлбэрт оруулж, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн програмд бүртгэн ажилласан.		
		Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж Захиргаа удирдлагын газарт хүргүүлэх.	Төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хүргүүлэн ажилласан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тус газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэхээр ажиллаж байна.		
		Тус газарт шинээр баригдах албаны барилгын шав тавих арга хэмжээг зохион байгуулах.	Барилга барих бэлтгэл ажлыг ханган ажилласан байна.	Нийт албан хаагчид	Өмнөд бүс дэх газрын албаны байрны шав тавих ёслолыг энэ оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулан ажиллалаа. Шав тавих ёслолын ажиллагаанд Гадаадын иргэн, харьяатын газрын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Ч.Тулгацоодол, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Дотоодыг хамгаалах тэнхимийн орлогч дарга Баян-Эрдэнэ, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ван Хай Фөн, барилгын ажил гүйцэтгэх компанийн захирал Сайшаалт, инженер техникийн ажилчид, оролцлоо.		
		Хяналтын улсын байцаагчид ашиглах баримтжуулалтын энгэрийн камер, бүлгийн хээрийн майхан, хэрэгслийн иж	Албан хаагчдыг иж бүрдэл хэрэгслээр хангах хөрөнгийн асуудлыг	Газрын дарга Хяналтын улсын ахлах байцаагч	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хяналтын улсын байцаагчид ашиглах техник хэрэгсэлийн зардалд 4,900,000 төгрөгийг Өмнөговь		

1	2	3	4	5	6	7	8
		бүрдлийн хөрөнгийг Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГ-аас шийдвэрлүүлэх.	шийдвэрлүүлэн ажилласан байна.		аймгийн Даланзадгад сумын ЗДТГ-аар шийдвэрлүүлэн ажилласан.		
6.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах.	Сүлжээний тасралтгүй хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Сүлжээний инженер	Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Бүсийн хэмжээнд гарсан 1 эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажилласан.		

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР